


“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2025 оны Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн тайлан

“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газар Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2025 оны 01 сарын 02-ны өдөр Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 4 зорилт, 14 арга хэмжээ хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Эдгээр ажлуудаас 10 ажил биелсэн нь 71 хувийн биелэлттэй байна. Үлдэх 4 ажлыг энэ 4 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлнэ.

Энэ оны хагас жилийн байдлаар хэрэгжүүлсэн дараах ажлуудаас:

1. АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн ажлыг Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн Ё.Мөнхтуяа болон бусад хэлтсийн ажилтнуудтай хамтран хэрэгжүүлсэн.
- 1.1. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх контент хийж, олон нийтийн мэдээлэл, дотоод сүлжээ, байгууллагын цахим хаяг, фэйс бүүк пэйжээр дамжуулж сурталчилсан.

<https://www.facebook.com/share/v/1JkZTGri64/>




“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЭЖ БАЙНА

Like Comment Share

117 · 4 comments · 9.7K Plays

2. Авилгын эсрэг нөлөөллийн арга хэмжээг орон нутаг дахь ТАЦ-үүдэд зохион байгуулах ажлыг АТГ, Төлбөр авах үйл ажиллагааны хэлтэстэй хамтран зохион байгуулсан.
- 2.1. Орон нутагт нийт 33 төлбөр авах цэгт ажилладаг ахлахуудад “Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг АТГ-тай хамтран зохион байгуулсан.



3. Авилгын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах ажлыг Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн Ё.Мөнхтуяатай хамтран хэрэгжүүлэв.
3.1. Төлөвлөгөөний дагуу хоёр (хойд, урд) байранд Авилгын хор уршиг, үр дагаврын талаар мэдээлэх мэдээллийн самбар байршуулж, тухай бүр мэдээлэл байршуулж, шинэчилж байна.



4. Шинээр томилогдсон албан хаагчдыг авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулах ажлыг АТГ-т сургалтын захиалга өгч баталгаажуулсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Авто замын барилга угсралтын ажил дуусахад энэ онд шинээр томилогдсон байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд, авто замын хяналтын инженерүүдийг хамруулан зохион байгуулахаар төлөвлөсөн.
5. Байгууллагын авилгаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.
5.1. Энэ оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар удирдах албан тушаалд ажиллах 13 албан тушаалтны Хувийн ашиг сонирхлын

урьдчилсан мэдүүлгийг тухайн албан тушаалд томилогдохоос өмнө АТГ-т хянуулсан байна. Хувийн ашиг сонирхлын зөрчил гэж тооцогдох нэг зөрчил илэрсэн бөгөөд тухайн албан тушаалд томилоогүй.

5.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын дүрэм, зохион байгуулалтын бүтцийн схем, албан тушаалын жагсаалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлуулсан. Шинэчилж батлуулсан дүрэмд хувийн ашиг сонирхол болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах эрх бүхий албан тушаалтанд тооцооны нягтлан бодогчийг нэмж, зөвхөн удирдах албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэхээс гадна гүйцэтгэх албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тэдэнд бүрэн эрх, албан үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэл, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилготой чухал арга хэмжээ байв.

5.3. Байгууллагын эрхэмлэх ёс суртахууны үнэт зүйлс, баримтлах ёс зүйн зарчим, дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоож, энэ төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх 2025 оны 1 дүгээр улиралд дараах хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг шинээр болон шинэчлэн батлуулж, мөрдүүлсэн. Үүнд:

- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам
- Ажилтны ёсзүйн дүрэм
- Ёс зүйн хорооны ажиллах журам

Ажилтны ёс зүйн дүрмийг Монгол Улсын Үндсэн хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хөдөлмөрийн тухай хуулд нийцүүлж, ажилтны нэр төр, алдар хүндийг хамгаалах, ажилтан бусад ажилтныг доромжлох, худал гүжирдлэг тараах, жендэрийн ялгаварлан гадуурхахыг хориглосон.

Түүнчлэн ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, бие махбодь, сэтгэл санааны дарамт үүсгэх, ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх, заналхийлэх, бэлгийн дарамт үзүүлэх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн үйлдэл, эс үйлдэхүйг хориглож, албан тушаалын чиг үүргээ гүйцэтгэхдээ хүнийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, гэрлэлтийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаврлан гадуурхахгүй байх зэрэг зохицуулалтыг нарийвчлан тусгаж, эдгээр зөрчил үүссэн тохиолдолд гомдол, мэдээлэл хүлээн авч, зөрчлийг шалгаж, дүгнэлт гаргах эрхтэй байнгын ажиллагаатай орон тооны бус Ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, ажиллах журмыг шинээр баталж, мөрдүүлсэн нь ажлын байранд үүсч болзошгүй дээрх зөрчлүүдээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой арга хэмжээ болсон.